



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/21

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрдэнэт мал сүргийнхээ тоо толгойг өсгөж, малын ашиг шимийн гарц, чанар, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, улс, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрээ үнэлүүлж Улсын “Аварга малчин” болсон Сүмбэр сумын 6 дугаар багийн малчин Ганболдын Одсүрэн, Баянтал сумын 2 дугаар багийн малчин Нацагдоржийн Баярсайхан нарыг тус бүр 1000000 (нэг сая) төгрөгний, МҮОНРТТелевизийн “Алтан төл”-ийн эздээр тодорсон Сүмбэр сумын 5 дугаар багийн малчин Бадамсамбуугийн Бадамцэрэн, 4 дүгээр багийн малчин Лхагвын Эрдэнэтогтох, Шивээговь сумын 2 дугаар багийн малчин Батсүхийн Отгонбаатар, Баянтал сумын 2 дугаар багийн малчин Адъяагийн Замзаах нарыг тус бүр 418,000 (дөрвөн зуун арван найман мянга) төгрөгний үнэ бүхий зүйлсээр шагнаж урамшуулсугай.

2.Улсын аварга малчин, Алтан төлийн эзнээр тодорсон малчдад хүндэтгэл үзүүлэх зардал 3,672,000 (гурван сая зургаан зуун далан хоёр мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ

